



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Үндсэн хуулийн цэцийн даргын 2014 оны
санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудит*

Аудитын код: YAG-/2015/23/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот

2015 оны 4 дүгээр сар



ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГЫН ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: Л.Одгэрэл
Утас: 260512
Цахим хаяг: odgerell@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Болормаа
Утас: 261628
Цахим хаяг: bolormaab@audit.gov.mn

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ
Хавсралт 2: Менежментийн захидал
Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн
тайлан
Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн
тайлан

Үндэсний Аудитын Газар

Засгийн газрын IY байр
Бага тойруу 6
Улаанбаатар-46
Монгол улс

Цахим хуудас: www.audit.mn

2015 оны 4 дүгээр сар

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийв.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2014 оны 4 дүгээр сарын 5-наас 2014 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Б.Болормаа хэрэгжүүлэв.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2014 оны 4 дүгээр сарын 5-наас 2014 оны 4 дүгээр сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг хуулийн хугацаанд Үндсэн хуулийн цэцийн удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар үйл ажиллагаагаа зохицуулж ажилладаг.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсөв боловсруулж, батлуулах, гүйцэтгэлийг хангах, тайлагнах үйл ажиллагааг төсвийн болон төрийн болон орон нутгийн өмч, санхүү, нягтлан бодох бүртгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн орчны хүрээнд хэрэгжүүлж байна.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт томоохон өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн цэц гэдэг нь:

- Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьдаг;
- Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргадаг;
- Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг магадлан шийдвэрлэх ийм гурван эрх, үүрэгтэй байна.

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.9-д “Үндсэн хуулийн цэцийн дарга Үндсэн хуулийн цэцийн төсвийн” ерөнхийлөн захирагч байна” гэж заасан байна. Үндсэн хуулийн цэцийн 2014 оны төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.9-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дарга Төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Үндсэн хуулийн цэцийн даргын 2014 оны 44 дүгээр тушаалаар Тамгын газрын даргаар (ерөнхий менежер) Д.Баянбилэгийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс томилсон байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Горим сорил хэрэгжүүлэх явцад бий болсон үр дүнгийн талаар ажлын баримтаар баталгаажуулж, цаашид анхаарах зарим асуудлыг энэ тайлангийн 2.10-д тусгав.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 7-г гүйцэтгэв.

Үндсэн хуулийн цэцийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна.

Үндсэн хуулийн цэцийн төсвийн санхүүгийн тайланг "Acolous 3.0" програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг төлөвлөсөн горимын дагуу сорьсон.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд төсвийн дотоод хяналтыг системийн эрсдэлийг "бага" гэж тооцсон болно.

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан алга байна. Энэ нь Төсвийн тухай 69 дүгээр зүйлийн 69.1-т "Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Үүнээс үзэхэд дотоод хяналтын системийг өөрийн байгууллагын онцлогийг тусгах замаар боловсронгуй болгох шаардлагатай байна.

Батлагдсан төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Үндсэн хуулийн цэцийн 2014 оны төсвийг Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 766.2 сая төгрөгөөр баталсныг бүрэн зарцуулсан байна.

Монгол Улсын 2014 оны Төсвийн тухай хуулиар Үндсэн хуулийн цэцийн даргын хөрөнгийн зардалд тусгагдаагүй байна.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг хавсралтаар үзүүлэв.

Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 791.3 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 15.8 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн дүнтэй дансанд гарсан ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа.

Аудитын явцад илрүүлсэн гол зөрчлүүд, гаргасан шийдлүүд

Төрийн аудитын байгууллага 2014 оны санхүүгийн тайланд аудит хийж, санал дүгнэлт гаргасан бөгөөд аудитын явцад илрүүлсэн зөрчил дутагдалд нэгтгэсэн байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг энэ тайлангийн 2.14-д хураангуйлан тэмдэглэв.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд анхаарал татах асуудал гараагүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Үндсэн хуулийн цэцийн даргын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад төлөвлөсөн горимын дагуу холбогдох чиглэлээр сорил гүйцэтгэсэн бөгөөд 2014 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

1. Зардал

Үндсэн хуулийн цэц нь нийт төсвийн зардлыг хэтрүүлээгүй боловч зарим зардлын хувьд авч үзвэл: шатахууны зардлыг 5.9 сая төгрөг буюу 16 хувиар, гэрэл, цахилгааны зардлыг 3.4 сая төгрөгөөр буюу 84 хувиар, гадаад томилолтын зардлыг 5.7 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар тус тус хэтрүүлэн зарцуулжээ. Энэ нь тус байгууллагын 2013 оны батлагдсан төсвийг Сангийн яамнаас бүрэн олгоогүй, бодит зардлыг төсөвт тусгаагүйтэй байсантай холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь:Төсвийн төлөвлөлтийг бодитой боловсруулж батлуулж байх талаар зөвлөмж өгөв.

2. Үндсэн хөрөнгө

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын аж ахуйн зохион байгуулагч нь няравын ажлыг хавсран гүйцэтгэдэг боловч “Эд хариуцагчийн бүрэн хариуцлагын тухай гэрээ” байгуулаагүй байгаа нь хөрөнгө дутагдах, алга болоход хариуцлага тооцох, төлүүлэх боломжгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.3-т заасны дагуу ажилтнуудтай “Эд хариуцагчийн бүрэн хариуцлагын тухай гэрээ”-г байгуулах.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн аудитын байгууллага 2013 оны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар өгсөн 3 зөвлөмжийн 2 нь хэрэгжсэн, нэг нь хэрэгжээгүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Санхүүгийн тайлангийн аудитаар Үндсэн хуулийн цэцийн хэмжээнд гарсан залруулаагүй алдаа, зөрчлыг нэгтгэж, материаллаг байдлын түвшинтэй харьцуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн тайланд зөрчилгүй өгөх санал дүгнэлтийн хэлбэрийг сонгосон болно.

Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн шударга илэрхийлэгдсэн байна.

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГЫН
ТӨСВИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1

Зардал

Асуудал 2

Үндсэн хөрөнгө

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг. Түүнд дотоод хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон ҮАГ-ын санхүүгийн аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Үндсэн хуулийн цэцийн санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Зардал**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Үндсэн хуулийн цэц нь нийт төсвийн зардлыг хэтрүүлээгүй боловч зарим зардлын хувьд авч үзвэл: шатахууны зардлыг 5.9 сая төгрөг буюу 16 хувиар, гэрэл, цахилгааны зардлыг 3.4 сая төгрөгөөр буюу 84 хувиар, гадаад томилолтын зардлыг 5.7 сая төгрөгөөр буюу 18.6 хувиар тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж байх” гэсэн заалтыг хэрэгжүүлж байх;

Асуудал 2: Үндсэн хөрөнгө**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын аж ахуйн зохион байгуулагч нь няравын ажлыг хавсран гүйцэтгэдэг боловч “Эд хариуцагчийн бүрэн хариуцлагын тухай гэрээ” байгуулаагүй байгаа нь хөрөнгө дутагдах, алга болоход хариуцлага тооцох төлүүлэх боломжгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Хөдөлмөрийн тухай хуулийн 135 дугаар зүйлийн 135.3-т заасны дагуу няравтай “Эд хариуцагчийн бүрэн хариуцлагын тухай гэрээ”-г байгуулах;



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ДАРГА Ж.АМАРСАНАА ТАНАА

2015.04.24 № 809
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Үндсэн хуулийн цэцийн төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	44,452.00	20,758.00
Кассанд байгаа бэлэн мөнгө	44,452.00	20,758.00
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/		
БАРАА МАТЕРИАЛ	6,611,247.80	7,164,607.80
Хангамжийн материал	6,611,247.80	7,164,607.80
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,655,699.80	7,185,365.80
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	-	-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,979,064,230.06	1,930,119,408.98
Биет хөрөнгө	1,977,414,230.16	1,920,329,409.10
Барилга, байгууламж	1,803,805,565.00	1,803,805,565.00
Хуримтлагдсан элэгдэл	(30,870,171.78)	(41,856,475.86)
Авто тээврийн хэрэгсэл	49,600,000.00	9,900,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(826,666.66)	(660,000.00)
Машин, тоног төхөөрөмж	127,704,960.00	75,508,119.00
Хуримтлагдсан элэгдэл	(74,718,288.60)	(31,009,401.64)
Тавилга, аж ахуйн эд хогшил	177,207,282.20	154,765,251.60
Хуримтлагдсан элэгдэл	(100,849,599.00)	(80,600,922.00)
Түүх соёлын дурсгалт зүйлс	11,160,000.00	11,160,000.00
Номын фонд	15,201,149.00	19,317,273.00
Биет бус хөрөнгө	1,649,999.90	9,789,999.88
Програм хангамж	7,810,000.00	16,500,000.00
Хасагдуулга	(6,160,000.10)	(6,710,000.12)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,979,064,230.06	1,930,119,408.98
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,985,719,929.86	1,937,304,774.78
Богино хугацаат өр төлбөр	288,073.28	415,456.28
Өглөг	288,073.28	415,456.28
Ажиллагчидтай холбогдсон өглөг	288,073.27	415,456.27
Бусад өглөг	0.01	0.01
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	288,073.28	415,456.28
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	288,073.28	415,456.28
Засгийн газрын оруулсан капитал	2,015,457,867.72	2,015,457,867.72
Өмнөх үеийн үр дүн	(36,581,972.32)	(36,581,972.32)
Тайлант үеийн үр дүн	-	(48,542,538.08)
Дахин үнэлгээний зөрүү	6,555,961.18	6,555,961.18
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,985,431,856.58	1,936,889,318.50
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,985,719,929.86	1,937,304,774.78

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	€МНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		
Улсын төсвөөс	753,883,500.00	766,177,700.00
Урсгал	584,683,000.00	766,177,700.00
Хөрөнгийн	169,200,500.00	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	448,820.00	6,944,437.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	448,820.00	6,806.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	6,937,631.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	754,332,320.00	773,122,137.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	-
АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	402,430,898.00	562,928,583.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	364,198,161.00	508,725,000.00
Цалин	364,198,161.00	508,725,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	38,232,737.00	54,203,583.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	32,022,165.00	46,248,072.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	25,042,804.00	36,237,885.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,916,863.00	3,558,051.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,512,384.00	5,073,161.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,550,114.00	1,378,975.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,210,572.00	7,955,511.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	117,951,471.03	161,918,315.74
Тогтмол зардал	10,490,747.92	17,837,506.00
Гэрэл цахилгааны зардал	4,080,390.00	7,389,356.00
Түлш, халаалтын зардал	6,122,778.00	10,105,660.00
Цэвэр, бохир усны зардал	287,579.92	342,490.00
Бусад бараа үйлчилгээний зардал	107,460,723.11	144,080,809.74
Бичиг хэргийн материал	8,224,264.00	5,438,850.00
Тээвэр, шатахууны зардал	28,931,070.00	42,799,789.73
Шуудан холбооны зардал	11,614,340.83	10,253,346.57
Дотоод томилолтын зардал	1,700,000.00	600,720.00
Гадаад томилолтын зардал	23,058,658.30	36,445,386.00
Ном, хэвлэлийн зардал	921,360.00	4,681,362.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,278,600.00	4,767,150.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	120,000.00	200,000.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	7,523,764.00	6,996,199.70
Урсгал засварын зардал	1,584,246.00	1,224,000.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	585,000.00	-
Гадаадын зочны зардал	1,020,810.00	1,439,994.00
Элэгдлийн зардал	20,808,609.98	26,783,411.74
Газрын төлбөр	-	2,390,600.00

Хог хаягдал устгах, цэвэрлэх	90,000.00	60,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	9,362,468.22	6,937,631.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	310,500.00	6,937,631.00
Сургалт семинарын зардал	310,500.00	-
Урьд оны өр	-	6,937,631.00
Төсвийн хуваарилагдаагүй зардал	9,051,968.22	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,051,968.22	-
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	79,027,737.00	59,531,812.00
Ажил олгогчоос өгөх бусад тэтгэмж	79,027,737.00	59,531,812.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,080,500.00	55,341,870.00
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	-	143,520.00
Шагнал, урамшил	2,947,237.00	4,046,422.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	608,772,574.25	791,316,341.74
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	145,559,745.75	(18,194,204.74)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
Хөрөнгийн орлого	-	8,690,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	8,690,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	39,038,333.34
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	39,038,333.34
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	145,559,745.75	(48,542,538.08)

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	€МН€Х ОН	ТАЙЛАНТ ОН
Тусламж, санхүүжилтын орлого	753,883,500.00	766,177,700.00
Улсын төсвөөс	753,883,500.00	766,177,700.00
Урсгал	584,683,000.00	766,177,700.00
Хөрөнгийн	169,200,500.00	-
Бараа, үйлчилгээний орлого	448,820.00	6,944,437.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	448,820.00	6,944,437.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	448,820.00	6,806.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	-	6,937,631.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	754,332,320.00	773,122,137.00
Ажиллагчидтай холбогдсон зардал	402,162,824.73	562,755,000.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	364,078,597.33	508,725,000.00
Цалин	359,183,597.33	371,453,863.00
Гэрээтийн цалин	-	104,347,764.00
Бусад нэмэгдлүүд	4,895,000.00	32,923,373.00
Унаа, хоолны хөнгөлөлт	4,895,000.00	17,874,019.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	38,084,227.40	54,030,000.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	31,159,822.40	50,100,973.91
Тэтгэврийн даатгалын шимтгэл	24,235,417.45	46,171,947.80
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,769,761.99	1,571,610.45
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,462,202.48	1,964,513.05
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	692,440.48	392,902.61
Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,924,405.00	3,929,026.09
Бараа үйлчилгээний урсгал зардал	94,021,607.05	135,734,464.00
Тогтмол зардал	10,490,747.92	17,837,506.00
Үр дүнгийн урамшуулал	-	15,049,354.00
Гэрэл цахилгааны зардал	4,080,390.00	7,389,356.00
Түлш, халаалтын зардал	6,122,778.00	10,105,660.00
Цэвэр, бохир усны зардал	287,579.92	342,490.00
Бусад бараа үйлчилгээний зардал	83,530,859.13	117,896,958.00
Бичиг хэргийн зардал	4,664,350.00	5,492,210.00
Тээвэр, шатахууны зардал	28,931,070.00	42,799,789.73
Шуудан, холбооны зардал	11,614,340.83	10,253,346.57
Дотоод томилолтын зардал	1,700,000.00	600,720.00
Гадаад томилолтын зардал	23,058,658.30	36,445,386.00
Ном, хэвлэлийн зардал	1,360,020.00	4,681,362.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,278,600.00	4,813,350.00
Зөөлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал	120,000.00	200,000.00
Төлбөр хураамж, жижиг татварууд	7,523,764.00	6,996,199.70
Урсгал засварын зардал	1,584,246.00	1,224,000.00
Биеийн тамирын уралдаан, тэмцээний зардал	585,000.00	500,000.00

Гадаадын зочны зардал	1,020,810.00	1,439,994.00
Газрын төлбөр	-	2,390,600.00
Хог хаягдал устгах, цэвэрлэх	90,000.00	60,000.00
Хөтөлбөр арга хэмжээний зардал	310,500.00	6,937,631.00
Төсвийн эрх захирагчдын арга хэмжээний зардал	310,500.00	6,937,631.00
Сургалт семинарын зардал	310,500.00	-
Урьд оны өр	-	6,937,631.00
ТАТААС	9,051,968.22	-
Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд	9,051,968.22	-
Бусад татаас, шилжүүлэг	9,051,968.22	-
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,051,968.22	-
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЗАРДАЛ	79,007,737.00	59,531,812.00
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	76,080,500.00	55,341,870.00
Ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал	-	143,520.00
Шагнал, урамшил	2,927,237.00	4,046,422.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	584,554,637.00	764,958,907.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	169,777,683.00	8,163,230.00
Хөрөнгийн орлого	-	-
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	171,669,789.00	8,186,924.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	171,669,789.00	8,186,924.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(171,669,789.00)	(8,186,924.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(1,892,106.00)	(23,694.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,936,558.00	44,452.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	44,452.00	20,758.00

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ	ХУРИМТЛАГДСА Н ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН
2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	2,015,457,867.72	6,555,961.18	(182,141,718.07)	1,839,872,110.83
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,015,457,867.72	6,555,961.18	(182,141,718.07)	1,839,872,110.83
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	145,559,745.75	145,559,745.75
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,015,457,867.72	6,555,961.18	(36,581,972.32)	1,985,431,856.58
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,015,457,867.72	6,555,961.18	(36,581,972.32)	1,985,431,856.58
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(48,542,538.08)	(48,542,538.08)
2014 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,015,457,867.72	6,555,961.18	(85,124,510.40)	1,936,889,318.50

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	ХУВЬ
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	766,208,200.00	766,208,200.00	-	100.0
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	766,208,200.00	766,208,200.00	-	100.0
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	766,208,200.00	766,208,200.00	-	100.0
Бараа, үйлчилгээний зардал	706,126,800.00	706,676,388.00	(549,588.00)	100.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	508,725,000.00	508,725,000.00	-	100.0
Үндсэн цалин	371,683,800.00	371,453,863.00	229,937.00	99.9
Унаа хоолны хөнгөлөлт	18,732,600.00	17,874,019.00	858,581.00	95.4
Нэмэгдэл цалин	105,874,800.00	104,347,764.00	1,527,036.00	98.6
Үр дүнгийн урамшуулал	12,433,800.00	15,049,354.00	(2,615,554.00)	121.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,030,000.00	54,030,000.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	34,226,000.00	46,171,947.80	(11,945,947.80)	134.9
Тэтгэмжийн даатгал	4,004,900.00	1,571,610.45	2,433,289.55	39.2
ҮОМШӨ ний даатгал	5,006,100.00	1,964,513.05	3,041,586.95	39.2
Ажилгүйдлийн даатгал	981,200.00	392,902.61	588,297.39	40.0
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	9,811,800.00	3,929,026.09	5,882,773.91	40.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	143,371,800.00	143,921,388.00	(549,588.00)	100.4
Бичиг хэрэг	5,120,000.00	5,492,210.00	(372,210.00)	107.3
Гэрэл цахилгаан	4,011,400.00	7,389,356.00	(3,377,956.00)	184.2
Түлш, халаалт	10,971,200.00	10,105,660.00	865,540.00	92.1
Тээвэр (шатахуун)	36,803,500.00	42,799,789.73	(5,996,289.73)	116.3
Шуудан холбоо	14,624,100.00	10,253,346.57	4,370,753.43	70.1
Цэвэр, бохир ус	2,333,300.00	342,490.00	1,990,810.00	14.7
Дотоод албан томилолт	1,300,000.00	600,720.00	699,280.00	46.2
Гадаад томилолт арга хэмжээ	30,719,200.00	36,445,386.00	(5,726,186.00)	118.6
Ном хэвлэл авах	10,456,000.00	8,797,486.00	1,658,514.00	84.1
Эд хогшил худалдан авах	516,000.00	515,900.00	100.00	100.0
Тавилга худалдан авах зардал	516,000.00	515,900.00	100.00	100.0
Нормын хувцас зөөлөн эдлэл	200,000.00	200,000.00	-	100.0
Урсгал засвар	1,224,000.00	1,224,000.00	-	100.0
Төлбөр хураамж болон бусад зардал	6,996,200.00	6,996,199.70	0.30	100.0
Гадаад зочны зардал	6,466,900.00	1,439,994.00	5,026,906.00	22.3
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,370,000.00	8,368,250.00	1,750.00	100.0
Хог хаягдал устгах цэвэрлэх	120,000.00	60,000.00	60,000.00	50.0
Биеин тамирын уралдаан тэмцээн	500,000.00	500,000.00	-	100.0
Газрын төлбөр	2,640,000.00	2,390,600.00	249,400.00	90.6
Татаас ба урсгал шилжүүлэг	60,081,400.00	59,531,812.00	549,588.00	99.1
Өрх гэрт олгох шилжүүлэг	60,081,400.00	59,531,812.00	549,588.00	99.1
Ээлжийн амралтаар нутаг явах	220,000.00	143,520.00	76,480.00	65.2
Шагнал урамшил	4,519,500.00	4,046,422.00	473,078.00	89.5
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,341,900.00	55,341,870.00	30.00	100.0

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	766,208,200.00	766,184,506.00	23,694.00	100.0
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	6,806.00	(6,806.00)	-
Төсвөөс санхүүжих	766,208,200.00	766,177,700.00	30,500.00	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	44,452.00	(44,452.00)	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	20,758.00	(20,758.00)	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСАД БҮГД	38.00	38.00	-	100.0
Удирдах ажилтан	10	10	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	16	16	-	100.0
Үйлчлэх ажилтан	12	12	-	100.0
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-